



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 03 өдөр

Дугаар А/746

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн “а”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар Алтай сумын Алтангадас багийн Тэсгэтэйн газрыг нөхөн сэргээсэн ажлыг хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын

дарга: Л.Батбаяр - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Гишүүд: Х.Түмэндэлгэр - Алтай сумын Засаг дарга

С.Долгормаа - Алтай сумын Засаг даргын Тамгын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч

Б.Түмэндэмбэрэл - Алтай сумын Засаг даргын Тамгын газрын Газрын даамал

С.Батдорж - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга

Б.Сэржмядаг - “Ариун уул булаг” зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөлийн тэргүүн

Нарийн бичгийн

дарга: Б.Ариундолгор - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн

2. Нөхөн сэргээлтийн ажлыг хүлээн авахтай холбогдон гарах зардлыг тухайн төслийн техник хяналтын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Нөхөн сэргээлтийн ажлыг холбогдох хууль дүрэм, журмын хүрээнд техникийн бичиг баримтад заасан үзүүлэлт, шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэхийг хянан баталгаажуулж, шийдвэр гаргахыг ажлын хэсгийн ахлагч /Л.Батбаяр/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН